



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн
хангамжийг зохицуулах журам батлах тухай

Монгол улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн Газар ба Олон улсын валютын сан хоорондын санхүүгийн хямралын үеийн төсвийн эх үүсвэргүй алдагдлыг нөхөх гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн зээлийн нөхцлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:


1. Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журмыг нэгдүгээр, амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус, тус баталсугай.
2. Жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсвийг эмнэлгийн эмийн зардалд тусгах арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Н.Түмэндэмбэрэл/, Эрүүл мэндийн газрын дарга, хоёрдугаар хавсралтад заасан эмнэлгийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
3. Журам батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн "Амин чухал эмийн жагсаалт батлах тухай" 70 тоот тушаалыг хүчингүй болгосугай.



САЙД

[Handwritten signature]

С. ЛАМБАА



Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Санхүү, эдийн засгийн хямрал болон бусад урьдчилан тооцоолох боломжгүй гэнэтийн хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад амин чухал үүрэгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн хомсдол үүссэн тохиолдолд тэдгээрийн хангамж, хүртээмжийг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Амин чухал эмийн нөөцийн бүрдүүлэлт

2.1 Бүх шатны эмнэлгийн байгууллагын дарга нар амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад заасан тухайн шатлалын эм, эмнэлгийн хэрэгсэл болон өөрийн эмнэлгийн онцлог тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу батлагдсан төсөвт өртөгтөө багтаан худалдан авч, тогтмол хоёр сарын нөөцтэй байлгана.

2.2 Эмнэлгийн эмийн сан уг жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тогтмол байлгаж, хүчинтэй хугацаанд байнга хяналт тавин, нөхөн сэлбэж, хадгална. Нөөцийн бүрдүүлэлт, нөхөн сэлбэлтэд Эмнэлгийн эмэн эмчилгээний хороо сар бүр хяналт тавина.

2.3 Эмнэлгүүд амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэхээр шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа, шаардлагатай тохиолдолд тодорхой тоо, хэмжээгээр тендерт санал болгосон үнээр нийлүүлэх талаар худалдан авах гэрээнд тусгана.

2.4 Эмнэлгийн байгууллагуудын саналыг үндэслэн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс хариуцана.

Гурав. Амин чухал эмийн нөөцийн зарцуулалт, тайлагналт

3.1 Эмийн санхүүжилт, үнийн өсөлт, нийлүүлэлт болон бусад урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлаас үүдэн эмнэлэгт эмийн тасалдал үүссэн тохиолдолд Эмнэлгийн эмэн эмчилгээний хорооны шийдвэрээр амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөөс зарцуулна.

3.2 Бараа, бүтээгдэхүүний суурь үнэ огцом өөрчлөгдсөн болохыг Засгийн газар, эдийн засаг, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн, үүнтэй шууд холбоотойгоор үндэсний хэмжээнд эмийн төсөв тасалдаж, хомсдол үүссэн тохиолдолд хоёр сар хүртэлх хугацаанд хангамжийг хэвийн түвшинд барих арга хэмжээ авна.


3.3 Хүн амын дархлаажуулалтад хэрэглэгдэх вакцины хангамжийг Дархлаажуулалтын тухай хууль болон Дархлаажуулалтын сангаар зохицуулна.

3.4 Эмнэлгүүдээс ирүүлж буй сар бүрийн үлдэгдэлийн мэдээгээр хот, хөдөөгийн нийт эмнэлгийн 40 хувь нь амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцөө зарцуулсан, нөхөх боломжгүй хүндрэл үүссэн эсхүл эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнэ огцом өөрчлөгдсөн болохыг Засгийн газар, Эдийн засаг, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газар болон хандивлагч байгууллагуудад асуудлыг тавьж төсөв нэмэгдүүлэх, хандив тусламж авах зэргээр хангамжийг зохицуулах арга хэмжээ авна.

3.5 Эмнэлгийн эмийн сангийн хариуцсан албан тушаалтан амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээг Эрүүл мэндийн яамны цахим мэдээний санд /www.moh.mn, шууд холбоос Licemed/ сар бүрийн тавны дотор оруулна.

3.6 Эмнэлгүүдээс ирүүлсэн амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээнд ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс хяналт тавина.

Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт



тун хэмжээ, хэлбэр

№	Эмийн нэр	тун хэмжээ, хэлбэр	сумын эмнэлэг	сум дундын эмнэлэг	аймаг дүүргийн эмнэлэг	клиникийн эмнэлэг, нарийн мэргэжлийн төв
1	Аминофиллин	25мг/мл-10мл тун шилтэй	*	*	*	*
2	Азотын дутуу исэл	баллон			*	*
3	Альбумин	10%-100мл			*	*
4	Атропин	1мг/мл (сульфат), 1мл тун шилтэй	*	*	*	*
5	Аминокапроны хүчил	т.уусмал, 400мг/мл 10мл тун шилтэй	*	*	*	*
6	Атракуриум бесилат	т.уусмал, 10мг/мл тун шилтэй				*
7	Бупивикайн	5мг/мл-20мл, 20мг/4мл			*	*
8	Гепарин	т.уусмал, 5 000 ОУН, 25000 ОУН/мл 1мл тун шилтэй	*	*	*	*
	Глицерил тринитрат	шахмал (хэлэн дор тавих), 500мг	*	*	*	*
10	Дибазол	10,20,50мг/мл-1-5 мл тун шил	*	*	*	*
11	Диазепам	т.уусмал, 5мг/мл 2мл тун шилтэй	*	*	*	*
12	Дифенгидрамин	тарилгын уусмал	*	*	*	*
13	Дроперидол	5мг/мл-2мл тун шилтэй			*	*
14	Дротаверин	20мг/мл 2мл туншил	*	*	*	*
15	Декстран 70	400 мл тарилгын уусмал	*	*	*	*
16	Допамин	40мг/мл 5мл туншил				
17	Инсулин	т.уусмал, 40 ОУН/мл; 80 ОУН/мл; 100 ОУН/мл 10 мл флаконтой	*	*	*	*
18	Кетамин	т. уусмал, 50мг/мл10мл тун шилтэй		*	*	*
19	Кордиамин/никетамид	25%-1 мл туншил	*	*		
20	Лидокайн	2%-2мл тун шилтэй	*	*	*	*
21	Магнийн сульфат	250мг/мл 10мл туншил	*	*	*	*
22	Маннитол	100мл, 200мл, 400мл тарилгын уусмал			*	*
23	Морфин г/х	т.уусмал, 10 мг (сульфат, гидрохлорид)1 мл тун шилтэй	*	*	*	*
	Метамизол	2мл туншил	*	*		
25	Неостигмин	2.5 мг (метилсульфат) 1 мл тун шилтэй			*	*
26	Окситоцин	т.уусмалд, 5 ОУН, 10 ОУН 1 мл тун шилтэй	*	*	*	*
27	Преднизолон	30мг/1мл тун шилтэй	*	*	*	*
28	Рингер- Лактатын уусмал	тарилгын уусмал	*	*	*	*
29	Суксаметоний хлорид	т.уусмал, 50 мг (хлорид)/мл 2 мл тун шилтэй			*	*
30	Строфантин G	тарилгын уусмал	*	*	*	*
31	Тиосульфат натри	30%-10мл тун шилтэй			*	*
32	Тиопентал	1гр тарилгын нунтаг			*	*
33	Фторотан	50.0мл флаконтай			*	*
34	Фуросемид	шахмал, 40мг, 10мг/мл 1 мл туншил	*	*	*	*
	Фентанил	0.0005% 2мл			*	*
36	Хлоропромазин	т.уусмал, 25 мг (г.хлорид)/1мл тун шилтэй ,шахмал, 100			*	*
37	Эпинефрин /Адреналин/	1мг/мл 1 мл тун шилтэй	*	*	*	*
38	Эфедрин	/гидрохлорид/ 50мг/мл 1 мл туншил			*	*
39	Марль	120см x1000м	*	*	*	*
40	Хөвөн	50гр	*	*	*	*

41	Хоосон вакуумтейнер /зүүтэй/	нэг удаагийн	*	*	*	*
42	Шингэн сэлбэх систем	нэг удаагийн	*	*	*	*
43	Нугасны мэдээ алдуулалтын зүү	нэг удаагийн			*	*
44	Мэс заслын нийлэг утас	нэг удаагийн /хайлдаг, хайлдаггүй/	*	*	*	*
45	Үзлэгийн бээлий	нэг удаагийн S,M,L	*	*	*	*
46	Мэс заслын бээлий	нэг удаагийн S,M,L ариутгасан	*	*	*	*
47	Уян зүү	нэг удаагийн 20G	*	*	*	*
48	Шээсний катетр	нэг удаагийн №14-16, 22-24	*	*	*	*
49	Мэс заслын хутга	нэг удаагийн №11, 15, 22-24	*	*	*	*
50	Цус, цусан бүтээгдэхүүн		*	*	*	*